

**ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭГ ХЯНАХ
БОЛОН ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ГЭРЭЭНД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь төр, хувийн хэвшлийн түншлэл (цаашид “түншлэл” гэх)-ийн төслийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, түншлэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шуурхай хэрэгжүүлэхэд оршино.

1.2.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцаанд энэ журмыг баримтална.

1.3.Энэ журмыг хэрэгжүүлэхэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

**Хоёр.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн
шинжилгээг хянаж, зөвшөөрөл олгох**

2.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.3-т заасны дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн төслийг түншлэлээр хэрэгжүүлэх саналтай танилцаж, тухайн төслийн бүрэн шинжилгээний тайлан, дүгнэлт болон мөн хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг мөн хуулийн 21.4-т заасны дагуу ажлын 15 өдөрт багтаан түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.1-д заасан зөвшөөрөл олгохдоо Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.5-д заасан дараах тооцоо, судалгааг үндэслэл болгоно:

2.2.1.нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлээр батлагдсан ерөнхий нөхцөл, эрэлт, нийлүүлэлт, тариф, зах зээлийн хувьсагч үзүүлэлт, тэдгээрт хийгдсэн эрсдэлийн дүгнэлт;

2.2.2.төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, төрөөс үзүүлэх дэмжлэгийн хүрээнд төсөвт тусгах урсгал болон хөрөнгө оруулалтын зардал, хөнгөлөлт, тэдгээрийн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад нийцсэн талаарх санал, дүгнэлт;

2.2.3.төрөөс үзүүлэх дэмжлэгийн хүрээнд төсөвт үзүүлэх болзошгүй өр төлбөрийн шинжилгээ, Засгийн газрын баталгаа гаргах төрөл хэлбэр, түүний

Төсвийн тогтвортой байдлын тухай болон Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх санал, дүгнэлт.

2.3.Энэ журмын 2.2.2-т заасан төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.2-т заасан загварын дагуу тооцож, дүгнэлт гаргана.

2.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийн бүрэн шинжилгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл зөвшөөрөл олгохоос татгалзах бөгөөд зөвшөөрөхгүй тохиолдолд үндэслэл, тайлбарыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.5.Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээг хянасны үр дүнд зарим асуудлыг тодруулах, нэмэлт мэдээлэл, баримт бичиг шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга авахаар түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад буцааж болох бөгөөд энэ тохиолдолд дахин зөвшөөрөл авахаар ирүүлэх болон зөвшөөрөл өгөх хугацаа нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.3, 21.4-т зааснаар байна.

Гурав.Түншлэлийн гэрээ байгуулах болон гэрээнд нэмэлт,
өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох

3.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн түншлэлийн гэрээ байгуулах болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлттэй танилцаж, сонгон шалгаруулалт, түншлэгчтэй хийсэн хэлэлцээний дүн, ажлын хэсгийн дүгнэлтийг төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаас хянаж, түншлэлийн гэрээ байгуулах эсэх болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх зөвшөөрлийг мөн хуулийн 26.4-т заасны дагуу ажлын 10 өдөрт багтаан олгоно.

3.2.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 39.1-д заасан тохиолдлыг тодорхойлж, түншлэлийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийн төслийг ирүүлэх бөгөөд түүнийг түншлэгч талууд харилцан зөвшилцөж, зөвшөөрсөн байна.

3.3.Энэ журмын 3.2-т заасан түншлэлийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгасан түншлэлийн төслийн нэмэлт ажил, үйлчилгээ нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 39.2-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд түүнийг хянан баталгаажуулж ирүүлсэн байна.

3.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Түншлэлийн гэрээ байгуулах болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй тохиолдолд үндэслэл, тайлбарыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад энэ журмын 3.1-д заасан хугацаанд албан бичгээр хүргүүлнэ.